



**ЗАМ, ТЭЭВРИЙН
ЯАМ**

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР

**ТӨМӨР ЗАМЫН ГАЗРЫН
2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ
2025 он

**ТӨМӨР ЗАМЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**
(жилийн эцсийн байдлаар)

2026.01.09

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

Төмөр замын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2025 оны А/310 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлж дүгнэх журам”-ыг үндэслэл болгосон.

Хоёр. Танилцуулга

Төмөр замын газрын 2025 оны үйл ажиллагааг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт, Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Сайд, ТНБД-ын тушаалын хэрэгжилт, Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт гэсэн 8 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 73.4%-тай байна. /Хүснэгт 1/

Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

2.1. МУ-ын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт:

Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн явц зорилтот түвшин				Хэрэгжилтийн хувь
	85 хувь буюу түүнээс дээш “үр дүнтэй”	60-84 хувь буюу “үр дүн хүлээгдэж байгаа”	30-59 хувь буюу “үр дүн хангалтгүй”	0-29 хувь буюу “үр дүн гараагүй”	
7	2	-	5	-	50

2.2. МУ-ын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт:

Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн явц зорилтот түвшин				Хэрэгжилтийн хувь
	85 хувь буюу түүнээс дээш “үр дүнтэй”	60-84 хувь буюу “үр дүн хүлээгдэж байгаа”	30-59 хувь буюу “үр дүн хангалтгүй”	0-29 хувь буюу “үр дүн гараагүй”	
6	1	-	5	-	41.7

2.3. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт:

Нийт	Үүнээс				Хэрэгжилтийн хувь
	100%	Хэрэгжих шатанд	0%	Хугацаа болоогүй	
57	37	20	-	-	87.4

2.4. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт:

Нийт заалт	Үүнээс					Хэрэгжилтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хэрэгжих боломжгүй	
117	77	35	-	4	1	84.4

2.5. Сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

Нийт заалт	Үүнээс					Хэрэгжилтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
29	23	2	1	2	1	92.3

2.6. ТНБД-ын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

Нийт заалт	Үүнээс					Хэрэгжилтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
10	9	-	-	-	1	100.0

2.7. Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ:

д/д	Үзүүлэлтийн бүлэг	Үнэлгээ (хувь)
1	Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	74.4
2	Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	27.4
3	Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	61.5
4	Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх ил тод, нээлттэй байдал	64.2
5	Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал	70.8
Дүн		62.1

2.8. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ:

Мэдээлэл оруулах тоо	Мэдээлэл оруулсан тоо	Үүнээс:			Гүйцэтгэлийн хувь
		Хугацаандаа	Хоцорсон	Мэдээлээгүй	
103	103	103	-	-	100.0

Гурав. Үнэлэлт, дүгнэлт
Төлөвлөлтийн байдал:

Засгийн газрын 2025 оны 73 дугаар тогтоол батлагдсантай холбогдуулан Төмөр замын газар энэ оноос байгуулагдан, үйл ажиллагаагаа эхэлсэн бөгөөд 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод

аудитын газраас өгсөн зөвлөмжийн дагуу арга хэмжээний зорилтот түвшнийг улирал бүрээр төлөвлөөгүй байна. /5.2, 5.7, 9.1-9.3, 11.1, 11.2, 12.2, 12.3/

Хэрэгжилтийн байдал:

1) Төмөр замын газрын 2025 оны үйл ажиллагааг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт, Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Сайд, ТНБД-ын тушаалын хэрэгжилт, Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 8 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 73.4%-тай байна.

2) Ганцмод боомтын хил дамнасан 19.5 км төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх ажлыг зорилтот түвшинд хүргэж ажиллаагүй бол, Арцсуурь-Шивээхүрэн-Нарийнсухайт чиглэлийн 1255 км төмөр замын төслийн хүрээнд Шивээхүрэн Нарийнсухайт-Шинэжинст чиглэлийн төмөр замын төслийг эхлүүлэх ажил ТЭЗҮ-ийн төслийг холбогдох ажлын хэсэг, салбарын шинжлэх ухаан, технологийн дэд зөвлөлөөр хэлэлцэж дэмжсэн боловч төслийг цааш хэрэгжүүлэх шийдвэр гарч, дараагийн шатанд шилжүүлсэн тухай баримт бичиг бүрдээгүйгээс хэрэгжээгүй байна.

3) Улаанбаатар-Шинэ Хархорум чиглэлийн 384 км төмөр замын төслийг эхлүүлэх ажлын ТЭЗУС боловсруулах ажил бүрэн дуусаагүй, эцсийн тайлан баталгаажуулж хангалттай холбоотой хэрэгжилт хангалтгүй түвшинд байна.

4) Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын 1955 оны хилийн төмөр замын хэлэлцээрийг шинэчлэх төслийг БНХАУ-ын тал эцэслэн боловсруулж, Монгол Улсын талд ирүүлээгүй байна.

5) 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 57 арга хэмжээний хэрэгжилт 87.4% байна. Үүнээс 89.5% нь хүрэх түвшиндээ бүрэн хүрсэн болон хүрэх шатандаа, 10.5% нь төлөвлөсөн үр дүндээ бүрэн хүрээгүй байна.

6) Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг зорилтуудаар нь авч үзвэл:

Зорилт	Зорилтот түвшин	Хэрэгжилтийн хувь
Зорилт 1. Төмөр замын тээврийн хэмжээг нэмэгдүүлнэ.	Төмөр замаар 50 сая.тн (ачааны хэмжээ 47.5 сая.тн)-оос доошгүй ачаа, 2.5 сая зорчигч тээвэрлэнэ	86.0
Зорилт 2. Хил дамнасан төмөр замуудын бүтээн байгуулалтыг эрчимжүүлнэ.	Гашуунсухайт-Ганцмод, Шивээхүрэн-Сэхээ боомтын хил дамнасан төмөр замын барилгын ажлыг эхлүүлнэ. Ханги-Мандал боомтыг Засгийн газар хоорондын хэлэлцээрт нэмж тусгана.	82.5
Зорилт 3. Төмөр замын сүлжээг өргөтгөж, 3200 км орчим төмөр замын бүтээн байгуулалтыг эхлүүлнэ.	Төслийн 1 түншлэгчтэй гэрээ байгуулна, 3 төслийн ТЭЗҮ-д бүрэн шинжилгээ хийнэ, 2 төслийн ТЭЗҮ-г ШУТЗ-өөр хэлэлцүүлнэ.	55.0
Зорилт 4. Төмөр замын сүлжээний ашиглалтын бэлэн байдлыг хангана.	Төмөр замын хөдөлгөөний удирдлагын барилгын ажлыг дуусгаж, системийн тоног төхөөрөмж суурилах ажлыг эхлүүлнэ. Замын их засварыг хийж дуусгана.	100.0
Зорилт 5. Төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй, түргэн шуурхай болгож цахимжуулж чанар хүртээмжийг сайжруулна.	Төмөр замын тээврийн үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй, шуурхай, оновчтой байдлаар зохион байгуулж цахимжуулна.	100.0

Зорилт 6. Төмөр замын тээврийн салбарын хөгжлийг дэмжсэн эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	Төмөр замын тээврийн 9 журмыг баталж, 12 журам, стандарт боловсруулж Зам, тээврийн яаманд хүргүүлнэ.	85.0
Зорилт 7. суурь бүтэц хоорондын галт тэрэгний хөдөлгөөнийг захирамжлан зохион байгуулна.	Төмөр замын сүлжээний тээх, нэвтрүүлэх чадвар, хөдлөх бүрэлдэхүүнийг бүрэн ашиглах нөхцөлийг хангасан галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагийг баталж мөрдүүлнэ.	87.5
Зорилт 8. Төмөр замын тээврийн статистик мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж хөтөлнө.	Мэдээллийг боловсруулж, дүн шинжилгээ хийж баталгаажсан, үнэн зөв мэдээллээр хангана.	100.0
Зорилт 9. Хөдлөх бүрэлдэхүүнд дугаар олгож, бүртгэл мэдээллийг хөтөлнө.	Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх журам, “Хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалт. MNS 6630-1,2,3,4:2016” стандартыг хэрэгжүүлнэ.	100.0
Зорилт 10. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хэрэгжүүлж, эрх зүйн зохицуулалтыг хангаж, санхүү, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг зохицуулж, хэрэгжүүлнэ.	Иргэн, хуулийн этгээдийн өргөдөл, гомдлыг 100 хувь шийдвэрлэнэ. Албан хаагчдыг эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулна.	92.8
Зорилт 11. Төмөр замын тээврийн салбарт Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, шалган шийдвэрлэнэ.	Төмөр замын тээврийн салбарт Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг 100 хувь хангуулна.	100.0
Зорилт 12. Төмөр замын тээврийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх, гүйцэтгэлийн хяналт шалгалт хийнэ.	Хяналт шалгалт хийж, улсын байцаагчийн акт, албан шаардлага, дүгнэлт, зөвлөмж хүргүүлнэ. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулж, биелэлтийг 80-аас доошгүй хувиар хангуулна.	70.0

7) Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээ, зорилтуудын хэрэгжилтийг хангахад шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэр бүрэн шийдвэрлэгдээгүй, мөн ТЭЗҮ боловсруулах, сайжруулах ажлууд хугацаандаа хийгдээгүй байна. Үүний улмаас төлөвлөсөн ажлуудыг хэрэгжүүлэх боломж бүрдээгүй байна.

8) Яам, тээврийн яамнаас 2025 оны 10-11 сард яам болон харьяа байгууллагуудын “Хяналт шалгалт болон аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт-д дотоод аудит хийж, ТЗГ-ын хэрэгжилт 22.0 хувь буюу хангалтгүй үнэлэгдсэн байна.

Хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээ хийсэн байгууллага	Акт, албан шаардлага, зөвлөмжийн тоо			Хувь
	Нийт	Үүнээс		
		Хэрэгжсэн	Хугацаа болоогүй	
ЗТЯ	9	2	-	22.0%

Энэ нь зөвлөмж, албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс гадна хэрэгжилтийг хангах төлөвлөгөөг боловсруулахдаа хэрэгжүүлэх арга хэмжээг оновчтой тодорхойлоогүй, хугацааг бодитой тооцоолоогүй, хариуцах эзэн нь тодорхой бус төлөвлөсөн, хэрэгжилтийг баримтад суурилан тайлагнаагүй, нотлох баримтыг хавсарган ирүүлээгүй зэргээс шалтгаалсан байна.

Дөрөв. Санал, зөвлөмж

1. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд туссан 30–59 хувийн хэрэгжилттэй (тус бүр 5) арга хэмжээг зорилтот түвшинд хүргэхэд чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээг авч, хэрэгжилтийн явцыг улирал тутам тайлагнах;

2. Төмөр замын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан хэрэгжилт хангалтгүй байгаа дараах арга хэмжээг зорилтот түвшинд хүргэн ажиллах. Үүнд:

- Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнансан 19.5 км төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх,
- Арцсуурь-Шивээхүрэн-Нарийнсухайт чиглэлийн 1255 км төмөр замын төслийн хүрээнд Шивээхүрэн Нарийнсухайт-Шинэжинст чиглэлийн төмөр замын төслийг эхлүүлэх,
- Улаанбаатар-Шинэ Хархорум чиглэлийн 384 км төмөр замын төслийг эхлүүлэх,
- Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын 1955 оны хилийн төмөр замын хэлэлцээрийг шинэчлэн байгуулах.

3. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган, Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам"-ыг тогтмол хэрэгжүүлж, байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг тогтмол шинэчлэн байршуулах;

4. Эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээний хүрээнд өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг сайжруулж, хэрэгжилтийг хангах төлөвлөгөө боловсруулан, уг төлөвлөгөөний биелэлтийг холбогдох байгууллагуудад тогтоосон хугацаанд нотлох баримт, материалын хамт бүрэн тайлагнадаг тогтолцоог хэвшүүлэх;

5. Цаашид хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө бүрэн тусгаж, төлөвлөлтийг зөв тодорхойлон, ажлаа бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч, хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллахыг зөвлөж байна.

**САЛБАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР**

**ТӨМӨР ЗАМЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН**
(жилийн эцсийн байдлаар)

№	Хяналтад байх арга хэмжээ	2025 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ	Тухайн улиралд төлөвлөсөн арга хэмжээ /Өссөн дүнгээр/	Хэрэгжилтийн хувь	Жинлэсэн хувь
1	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	7	7	50.0	20
2	Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	6	6	41.7	20
3	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	57	57	87.4	20
4	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	117	112	84.4	20
5	Сайдын тушаалын хэрэгжилт	29	26	92.3	10
6	Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилт	10	9	100.0	10
7	Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ	25	25	62.1	10
8	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	103	103	100.0	10
Нийт		354	345	73.4	